



“МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 3-р сарын 16 өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай

“Монгол Улсын Компанийн тухай хууль”-ийн 59.4 дүгээр зүйл, “Монгео” ХК-ийн дүрмийн 6.2 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ :

Нэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10 цагт “Монгео” ХК-ийн 8 тоот өрөөнд хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

а. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн жилийн эцсийн тайлангын талаар ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэлэлцэж батлах,

б. Санхүүгийн тайланг үнэлсэн “Шинэ Их Тэрбум Аудит” ХХК-ийн дүгнэлтийг сонсгох,

в. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд компани идэвхтэй оролцох, шаардагдах төсвийг тооцож ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх,

г. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний гэрээ хэлцэл байгуулах, зээл авахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөх,

д. ХУДүүрэгт байрлалтай компанийн эзэмшлийн газрыг ашиглах, түрээслэх үйл ажиллагааг зохион байгуулахыг гүйцэтгэх удирдлагад даалгах,

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар хувьцаа эзэмшигч Н.Соёмбыг томилсугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Үүнд : Комиссын дарга : Х.Анар

Комиссын нарийн бичгийн дарга : Э.Норовринчин

Тав. Хурлын тооллогын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Үүнд : Комиссын дарга - Н.Бат-өлзий

Гишүүд: Г.Даваажаргал

Б.Түмэнжаргал

Зургаа. 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай мэдэгдэх хугацааг 2024 оны 03 сарын 21 ны өдөр , 2024 оны 04 сарын 05 ны өдөр байхаар тус тус тогтоосугай.

Долоо. Нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 4-р сарын 5-ны өдөр байхаар тогтоосугай.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах зохион байгуулалтын ажиллагаанд компанийн тухай хуулийн 59.8, 59.9 дэхь заалтуудыг хэрэгжүүлж ажиллахыг комиссын дарга - / Х.Анар/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ийн дарга...../Н.Соёмбо /

